
Халдварт өвчин судлалын мэргэжлийн сургалт эхэлсний 90 жил (1932-2022), АШУҮИС-ийн АУС-ийн Халдварт өвчин судлалын тэнхимийн 75 жил (1947-2022), Монголын Халдвартын эмч нарын нийгэмлэгийн 11 жилийн (2011-2022) түүхэн хөгжил

Орчин цагийн халдварт өвчин судлалын салбарын хөгжилд халдварт өвчин судлал (халдварт өвчин, сүрьеэ, БЗДХ)-ын сургалт томоохон суурийг эзэлдэг. Тэртээ 100 жилийн өмнө 500 мянга гаруйхан хүн амтай Монгол улс дэлхий дахинаа “Сөнөж мөхөж байгаа гадаад Монгол” хэмээн нийтлэгдэж, иргэдийнх нь дунд сүрьеэ, тэмбүү, заг хүйтэн, бодоо, гэдэсний хижиг зэрэг нийтийн халдварт өвчин өргөн тархсан, 3 хүртэлх насны хүүхдийн тал нь энддэг, тарваган тахал мэтийн байгалийн голомтот халдварт өвчин үе үе дэгдэж айл хотлыг бүхэлд нь сүйрүүлж байжээ. Ардын засгийн газар, цэргийн зөвлөлийн 1921 оны хурлаар цэрэг, ардын дунд халдварт өвчин ихсэж байгааг зориуд цохон тэмдэглэж 1921 оны 8-р сарын 15-нд цэрэг, энгийн ардыг үнэ төлбөргүй эмчлэх эмнэлэг байгуулах тухай Монголын ардын цэргийн зөвлөлийн тогтоол гаргаж, 1923 онд дотор, мэс засал, арьс өнгөний 10 гаруй эмчийг Орос улсаас урьж, 1924 онд “улаан цэргийн лазарет” гэдэг нэртэйгээр 36 ортой дотор (сүрьеэгийн тасгийн хамт), мэс засал, яр хүйтний гурван тасагтай шинжлэх ухааны эмнэлгийг байгуулсанаар 1907 оноос эхлэлтэй Оросын эмч мэргэжилтэний орчин цагийн анагаах ухаанд суурилсан эмнэлгийн тусламж үйлчилгээ өргөжин хөгжиж эхэлжээ.

Монгол улсын нутаг дэвсгэрт тарваган тахлын дэгдэлт тогтмол бүртгэгдэн хүн амыг айл хотлоор нь сүйрүүлж байсан учраас 1929 оны 1-р сарын 15-ны өдөр Улаанбаатар хотод байгуулагдсан сувилагчийн сургуулийг 1931 онд Засгийн газрын 17-р тогтоолоор хүн эмнэлгийн техникум болгон өргөжүүлж, 1932 оноос эхлэн “тахлын мэдээлэгч санитар” нэртэй анхан шатны албанд 30 гаруй хүнийг курсээр бэлтгэн сургаж голомтот нутгуудад ажиллуулсан нь орчин цагийн анагаах ухааны халдварт өвчин судлалд эмнэлгийн үндэсний мэргэжилтэнг сургасан сургалтын эхлэл гэж үзэхээр байна. 1938 онд Ленинградад АУДэС-ийг төгсөж ирсэн их эмч нарын нэг Б. Гонгоржав арьс өнгөний анхны Монгол их эмч мэргэжилтэн байсан бөгөөд 1942 онд МУИС-ийн хүн эмнэлгийн факультет байгуулагдсанаар Монгол улсад дээд боловсролтой үндэсний эмнэлгийн мэргэжилтэн - их эмч төрөн гарах болжээ.

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1947 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 12-р тогтоолоор Халдвартын больниц байгуулагдсанаар Монгол улс халдварт өвчин судлалын сургалтыг зохион байгуулах баазтай болсон байна.

Монгол улсын Сайд нарын Зөвлөлийн 1946 оны 10-р сарын 4-ний өдрийн 64-р тогтоолоор 1946-1947 оны хичээлийн жилд МУИС-ийн профессор-багшлах боловсон хүчний бүрэлдэхүүнд Валентина Николаевна Черноваг 1947 оны 7-р сарын 1-нээс халдвартын тэнхимийн эрхлэгч хэмээн тусгажээ (Зураг 1). В. Н. Чернова нь Монгол улсад 1945 оны 9-р сарын 1-нээс ирж ажиллаж байсан мэргэжилтэн байжээ.



ПО МИНИСТЕРСТВУ ПРОСВЕЩЕНИЯ МНР

№ ___

От "11" октября 1946 года.

§ 1.

В соответствии с постановлением Совета Министров МНР от 4 октября с.г. за № 64 установить следующий штат профессорско-преподавательского персонала и утвердить персональные должностные оклады по Монгольскому государственному университету им.Чойбалсана на 1946/47 учебний год.

ШТАТ И ПЕРСОНАЛЬНЫЕ ОКЛАДЫ

ПРОФЕССОРСКО-ПРЕПОДАВАТЕЛЬСКОГО и УЧЕБНО-ВСПОМОГАТЕЛЬНОГО ПЕРСОНАЛА МОНГОЛЬСКОГО ГОСУДАРСТВЕННОГО УНИВЕРСИТЕТА им.ЧОЙБАЛСАНА на 1946/47 учебн.год.

- 5 -

№ № п.п.	Земилия.	должность	ученое звание	ученая степень	стаж работы в ВУЗе	год. наг. час.	мес. окл. туг.	с какого времен
2	3	4	5	6	7	8	9	
	1У. Кафедры обслуживающие медицинский факультет.							
	21. Кафедра микробиологии:							
	Буров К.Д.	зав.каф.- ст.препод.	-	-	10	330	910	1.УПсов
		лаборант	-	-	-	-	500	ваканс.
		Почасовая оплата:				150		
	22. Кафедра патологической анатомии с секционным курсом.							
	Полякова К.К.	зав.кафед.	-	канд.	10	490	520	1.1Х
	Иванова К.П.	лаборант	-	-	-	-	400	1.1Х
	Баженова	препаратор	-	-	-	-	100	1.1Х
	23. Кафедра инфекционных болезней							
	Чернова В.Н.	зав.кафед. - ст.препод.	-	-	-	630	1320	1.УП
	24. Кафедра госпитальной хирургии.							
	Анфилогов С.Н.	зав.каф.	доц.	канд.	11	341	1680	1.УП
	Гантулга	ассистент	-	-	-	[illegible]	300	1.1Х
	25. Кафедра факультетской и госпитальной терапии							
	Боровская В.А.	зав.кафед.	-	канд.	10	374	2520	1.УП
	Хромушин В.Н.	ассистент	-	-	-	360	800	1.1Х
	Елисеева Т.В.	лаборант	-	-	-	13	600	1.1Х

Документы кафедру

Зураг 1. Монгол улсын Сайд нарын Зөвлөлийн 1946 оны 10-р сарын 4-ний өдрийн 64-р тогтоол, хавсралт

1946-1947 оны хичээлийн жилд 4-5-р курсын оюутнуудад хүүхдийн халдварт өвчний хичээл дизентери-цусан суулга, колит, энтерит, туберкулез, корь, краснуха, дифтерия, грипп, малярия, скарлатина зэрэг сэдвүүдээр хичээл орж байжээ. 1947-1948 оны хичээлийн жилд тарваган тахал сэдвээр 40 цагийн дадлагын хөтөлбөрийг улсын тарваган тахал эсэргүүцэх төв станцын дарга, тухайн үедээ МУИС-ийн микробиологийн тэнхмийн эрхлэгчээр хавсран ажиллаж байсан дэд эрдэмтэн В.П.Смирнов боловсруулан доцентийн курсийн хэмжээнд 5-р курст зааж байжээ Халдварт өвчин судлалын тэнхимд 1947-1948 онуудад оросын мэргэжилтэнүүд (1948 он - н.Медак, тэнхимийн туслах ажилтан, 1949 он- Малышев Александр Николаев - ахмад багш, н.Гисматулин хошууч, багш, В.П.Смирнов - багш) нар ажиллаж, 1950 оноос Халдвартын больниц (Зураг 2) - ын ерөнхий эмчээр ажиллаж байсан халдвартын анхны монгол эмч В.Гаамаа (Зураг 3) багшилж эхэлсэн байна.



Зураг 2. Халдвартын больниц (1958 он)



Зураг 3. Халдвартын анхны монгол эмч, Монгол улсын Хүний Гавъяат эмч, Анагаах ухааны дэд эрдэмтэн В. Гаамаа



Зураг 4. Баруун талаас залуу багш Г.Дуламсүрэн, Халдвартын тэнхмийн эрхлэгч Ю.М.Михайлова нар больницын эмч нарын хамт 1953 он. Улаанбаатар хот

1952 оноос тус тэнхимд оросын мэргэжилтэн багш В.И.Богданова, И.П.Баркова /тарваган тахал зааж эхэлсэн/ нар багшилж, 1953-оны 9-р сарын 1-нээс Анагаах ухааны дэд эрдэмтэн Ю.М.Михайлова тэнхимийн эрхлэгчээр ажиллаж эхэлжээ (Зураг 4).

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1954 оны 01-р сарын 17-ны өдрийн 21-р тогтоолоор МУИС-ийн Анагаах ухааны салбарын дэргэд Халдвартын тэнхимийг хүүхдийн тэнхимтэй нэгтгэн “Хүүхэд ба халдвартын тэнхим” нэртэй байгуулж,

тэнхимийн эрхлэгчээр Анагаах ухааны доктор, доцент Д.Намсрайжав (Зураг 5), багшаар дэд эрдэмтэн Д.С.Розова, Г.Дуламсүрэн, Ц.Цэрэндаш нар ажиллаж байжээ.



Зураг 5. Анагаах ухааны доктор, доцент Д.Намсрайжав

Микробиологи, халдварт өвчний тэнхимийг 1956 оны 8-р сарын 28-ны өдрөөс 1958 оны 7-р сарын 1-ний хооронд дэд эрдэмтэн Т.А.Страхова удирдаж (Зураг 6), Г.Жамба /ахлах багш, микробиологи/, Г.Дуламсүрэн /багш, халдварт өвчин/, Г.Санжмятав /багш, микробиологи/, С.Тэрбиш /багш/, 1957 -1958 оны хичээлийн жилд дээрх багш нараас гадна Л.Дамдинсүрэн /багш, халдварт/, М.А.Беляева /цагийн багш, халдварт/, Ж.Дашдаваа /багш, халдварт/, С.Тэрбиш / лаборант/, н.Нацагюм /лаборант/ ажиллахын зэрэгцээ 1955 онд Эрхүү хотын тарваган тахал эсэргүүцэх хүрээлэнгийн нарийн мэргэжил эзэмших курст суралцаж төгссөн их эмч Ц.Отгон, Ш.Самбуу нар тарваган тахлын хичээл зааж байсан байна.



Зураг 6. Халдвартын тэнхимийн эрхлэгч Т.А.Страхова эмч нарт хичээл зааж байгаа нь: баруун талаас 2 дахь залуу багш Г.Дуламсүрэн 1957 он, УБ хот

1958 оны 4-р сарын 15-ны өдрөөс МУИС-ийн ректорын тушаалаар 1959-1960 оны хичээлийн жилд микробиологи, халдварт өвчин судлалын тэнхимийн эрхлэгчээр Г.Жамбыг томилж (Зураг 7), Г.Дуламсүрэн /багш, халдварт өвчин/, Г.Санжмятав /багш, микробиологи/, Л.Дамдинсүрэн /багш, халдварт/ нар багшаар ажиллаж байжээ.



Зураг 7. Анагаах Ухааны доктор, Профессор Г. Жамба

МАХН-ын Улс төрийн товчооны 1961 оны 5-р сарын 17-ны өдрийн 179-р тогтоол, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1961 оны 8-р сарын 16-ны өдрийн 431-р тогтоолоор 1961-1962 оны хичээлийн жилээс МУИС-ийн хүн эмнэлгийн факультетийг тусгаарлан АУДэС байгуулагдахад Халдвартын тэнхимийн эрхлэгчээр Г.Дуламсүрэнг томилж (Зураг 8), тэнхимийн багшаар Л.Дамдинсүрэн, лаборантаар С.Тэрбиш нар үргэлжлүүлэн ажилласан байна.



Зураг 8. Г. Дуламсүрэн, Халдвартын тэнхмийн анхны монгол эрхлэгч, Дэд эрдэмтэн, доцент, ординатур эмчийн хамт

1963-1964 онд Л.Дамдинсүрэн тэнхимийн эрхлэгчээр, н.Гомбосүрэн тэнхимийн багшаар, С.Тэрбиш лаборантаар ажиллаж байгаад 1964 оны 12-р сарын 26-наас дэд эрдэмтэн Г.Дуламсүрэн тэнхимийн эрхлэгчээр дахин

ажиллаж Л.Дамдинсүрэн /багш/, Чойндонгийн Дангаа /багш/, Жигжидийн Цэрэнбатаа /лаборант/ нарын бүрэлдэхүүнтэй болсон байна. Дэд эрдэмтэн Г.Дуламсүрэн 1977 он хүртэл тэнхимийн эрхлэгчийн ажлыг хашиж байсан бөгөөд халдвартын тэнхим 1965-1967 онд Л.Дамдинсүрэн /багш/, Гөлгөөгийн Цэрэндагва / багш, 1964 оноос/, Өлзийтийн Одхүү /лаборант, 1964 оноос/, Жалхаагийн Долгор /лаборант, 1967 оноос-1983 он хүртэл/, 1968 онд хүүхдийн их эмч Дашбалбарын Мандах багшаар /1973 он хүртэл/, 1975 оноос Содовын Сүхбаатар /багш/ нарын бүрэлдэхүүнтэй байжээ. Энэ үед Оросын зөвлөх, эрдэмтэд Монголд ирж хамтран ажиллахын хамт эрдэм судлалын ажлыг хийж гүйцэтгэж байжээ (Зураг 9-12).



Зураг 9. Баруун гар талаас тэнхимийн эрхлэгч Г.Дуламсүрэн, багш Н.Мандах, лаборант Ж. Долгор, багш Л.Дамдинсүрэн, Г.Цэрэндагва (1968 он).



Зураг 10. Урд эгнээнд баруун гараас зөвлөлтийн мэргэжилтэн доцент Ю. Я.Венгеров, Тэнхмийн эрхлэгч дэд эрдэмтэн доцент Г.Дуламсүрэн, ерөнхий эмч н.Дашдэндэв, Арын эгнээнд баруун талаас А. Цэнджав (хожим Сувилахуйн сургуулийн халдвартын багшаар ажилласан), Т. Дэлгэр (хожим Монгол улсын Хүний Гавъяат эмч болсон) зэрэг халдвартын эмч нарын хамт (1972 он)



Зураг 11. Халдвартын больницын 20 жилийн ойд зориулсан эмч нарын эрдэм шинжилгээний хурал: Зүүн гар талаас: Зөвлөх эмч Губеров, ерөнхий эмч В.Гаамаа, тэнхмийн эрхлэгч Г.Дуламсүрэн, намын үүрийн дарга Батсүх, эмнэлэг эрхэлсэн орлогч дарга Хишигдорж



Зураг 12. Багш Д. Мандах хичээл зааж байгаа нь

1977 оноос Дэд эрдэмтэн Л.Дамдинсүрэн (Зураг 13) халдвартын тэнхимийн эрхлэгчээр томилогдон 1984 он хүртэл ажиллахад тэнхимийн бүрэлдэхүүнд Гөлөгийн Цэрэндагва /багш/, Содовын Сүхбаатар /багш/, Ж.Долгор /лаборант/ нар ажиллаж байгаад 1978 оноос Намхайн Жанцан багшаар/1988 он хүртэл/, Чимэдийн Ценгарав лаборантаар, 1979 оноос Түвдэнгийн Няндагжид багшаар, 1983 оноос Адийхүүгийн Ариунаа лаборантаар ажилласан байна. Тэр үед Зөвлөлтийн мэргэжилтэн дэд эрдэмтэн Ю.П.Дерягин /1982-1986/, В.И.Улакаев/1988-1989/ нар тэнхимийн зөвлөх багшаар ажиллаж байжээ (Зураг 13-19). Тухайн үед Халдвартын больницын их эмч Агваанцэрэн, Ж.Баатар, А.Хажид нар дадлагын хичээлийг удирддаг байсан байна.



Зураг 13. АУ-ны доктор дэд профессор Л.Дамдинсүрэн



Зураг 14. Тэнхмийн эрхлэгч Л.Дамдинсүрэн лаборант Ж.Долгорын хамт




Зураг 15. Зүүн гар талаас: Г.Цэрэндагва (1980 он) багш оюутнуудтай



Зураг 16. Багш Н. Жанцан дадлагын хичээл удирдаж байгаа нь



Зураг 17. Багш С.Сүхбаатар багш оюутнуудтай



Зураг 17. Багш Т.Няндагжид оюутны хамт хичээл удирдаж байгаа нь



Зураг 18. Зүүн гар талаас урд эгнээнд: Г.Цэрэндагва, зөвлөх Ю.П.Дерягин, тэнхимийн эрхлэгч Л.Дамдинсүрэн, арын эгнээнд: С.Сүхбаатар, Н.Жанцан, А.Ариунаа, Т.Няндагжид (1982 он)



Зураг 19. Зүүн гар талаас урд эгнээнд: Н.Жанцан, И.Улакаев гэргийн хамт, арын эгнээнд: С.Сүхбаатар, Г.Цэрэндагва, тэнхимийн эрхлэгч Л.Дамдинсүрэн, Т.Няндагжид



Зураг 20. Монгол улсын Гавъяат багш Г.Цэрэндагва

Монгол улсын Гавъяат багш Г.Цэрэндагва 1984 оноос халдвартын тэнхимийн эрхлэгчээр томилогдож, тус тэнхимд С.Сүхбаатар /багш/, Н.Жанцан /багш/, Т.Няндагжид /багш/, А.Ариунаа лаборантаар /1991 он хүртэл/, 1986 оноос Гүрсэдийн Олзвой /багш/ нар багшилж байжээ (Зураг 19). Тэнхмийн үйл ажиллагаанд "Элэгний" хэмээн овоглогдсон Монгол улсын Хүний гавъяат эмч Т.Дэлгэр байнга хамтран ажиллаж 50 гаран жил багшилж байна (Зураг 21).



Зураг 21. Монгол улсын Хүний гавъяат эмч Т. Дэлгэр

Энэ үед тэнхимд 1988 оноос Б.Байгал (Зураг 22), Я.Дагвадорж, 1989 оноос Г.Зулхүү (Зураг 23), Н.Хоролсүрэн (Зураг 24), Д.Жаргалсайхан (Зураг 25), Б.Баярмагнай (Зураг 26), Р.Баяана, 1990 оноос Р.Оюунгэрэл, 1993 оноос Ж.Баярмаа (Зураг 27) багшаар, Т.Алтанцэцэг 1992-1997 онд Эмнэлгийн ажилчдын мэргэжил дээшлүүлэх институтэд "Халдварт өвчин судлал"-ын багшаар (Зураг 28), 1991-2019 онд С.Ганцэцэг лаборантаар (Зураг 29), Мөнхцэцэг, н.Хонгорзул, н.Яшил, н.Мөнхбат, н.Тамир, н.Оюун, зэрэг туслах ажилтан, үйлчлэгч нар ажиллаж байсан. Тэнхимийн эрхлэгч Г.Цэрэндагвын Монгол улсын анагаах ухааны боловсрол, эрүүл мэнд түүний дотор халдварт өвчин судлалын салбарт оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлж 1992 онд Монгол улсын Гавъяат багш цол тэмдгээр шагнажээ. Г.Цэрэндагва багш маань гайхамшигтай эмч, багш, удирдагч байсан. Түүний даруу төлөв, үнэнч шударга, аливаад чин сэтгэлээс ханддаг нөр хичээнгүй "Бурхан эмч"-ийн ухаанаар халдварт өвчин судлалын тэнхим нь сургалт, мэргэжлийн үйл ажиллагааг өндөр чанартайгаар зохион байгуулах чадвартай хамт олон болтол өсөн хүмүүжсэн (Зураг 30, 31).



Эрүүлийг Хамгаалахын Гавьяат Ажилтан Г.Олзвой Анагаах ухааны доктор, профессор



Зураг 22. Б. Байгал, Анагаах ухааны магистр клиникийн профессор



Зураг 23. Г. Зулхүү Анагаах ухааны доктор, дэд профессор



Зураг 24. Н. Хоролсүрэн Анагаах ухааны доктор



Зураг 25. Д. Жаргалсайхан Анагаах ухааны доктор



Зураг 26. Б. Баярмагнай Анагаах ухааны доктор, дэд профессор



Зураг 27. Ж. Баярмаа Анагаах ухааны доктор



Зураг 28. Т. Алтанцэцэг Анагаах ухааны доктор, профессор



Зураг 29. С. Ганцэцэг



Зураг 30. Зүүн гар талаас: Г.Жаргал, Г.Цэрэндагва, Т.Дэлгэр, Г.Зулхүү (1989 он)



Зураг 31. Зүүн гар талаас тэнхимийн эрхлэгч Г.Цэрэндагва, урд эгнээнд: С.Ганцэцэг, Т.Дэлгэр, Н.Хоролсүрэн, Д.Жаргалсайхан, арын эгнээнд: Г.Зулхүү, Б. Байгал, Б.Баярмагнай, Р.Оюунгэрэл, Л.Дамдинсүрэн, Т.Няндагжид (1992 он)

1995 оноос Анагаах ухааны доктор Я.Дагвадоржийг тэнхимийн эрхлэгчээр томилохын (Зураг 32) хамт тус тэнхимтэй тархвар судлалын салбарыг нэгтгэснээр АУ-ны доктор дэд профессор Т.Гомбосүрэн (Зураг 33), клиникийн профессор Ц.Чулуунбаатар (Зураг 34), багш Б.Ганбат, 1997 оноос Г.Даваа (Зураг 35), нар тус тэнхимийн багшаар, 2001 оноос О.Баатархүү халдварт өвчин судлалын хичээл заах багшаар ажиллаж эхэлсэн. Тэнхимийн дэд профессор Т.Гомбосүрэнгийн тархвар судлалын асар баян эрдэмлэг туршлага, хамт олонч халуун дулаан сэтгэл нь халдварт өвчин судлалын тэнхимийн хамт олонд эмнэлзүйн төдийгүй халдварт өвчний тархвар судлалын асуудлыг зэрэгцүүлэн судлах, сургах чиг хандлагыг төлөвшүүлсэн. “Чума Чука” нэрээр эрүүл мэндийн салбарт алдаршсан Ц.Чулуунбаатар багш маань “БНМАУ-д гоц аюулт халдварт өвчинтэй тэмцсэн түүх” 2 боть номыг туурвиж түүнээсээ залуу багш нарт хүүрнэн ярилцдаг байсан нь өнөө үеийн ололт амжилт бүхэн ахмад үеийнхний нөр хичээнгүй хөдөлмөр, зөв цэгцтэй бодлогоор хэрхэн хөгжиж ирснийг алхам тутамдаа санаж явахын дууриалал болсон.




Зураг 32. Тэнхмийн эрхлэгч Анагаах ухааны доктор, Профессор, АШУҮИС-ийн “Хүндэт профессор” Я.Дагвадорж



Зураг 33. Анагаах ухааны доктор, дэд профессор, Т.Гомбосүрэн





Зураг 34. “Чума Чука, Ц.Чулуунбаатар багш, лабораторид



Зураг 35. Г.Даваа, Анагаах ухааны доктор, Профессор

Профессор Я.Дагвадорж эрдмийн туршлага, ухаанаараа тэнхимийн эрдэм судлалыг шинэ шатнаа хөгжүүлж, тэнхимийн эрхлэгчээр ажиллах хугацаанд тэнхимийн багш нарыг удирдан чиглүүлж ялангуяа вируст хепатит өвчний чиглэлээр дэлхийн жишигт нийцэхүйц судалгааг өөрийн хүч нөөцөөр бий болгосон жижиг боловч тухайн цаг үедээ шинэлэг лабораторийн аргын тусламжтайгаар гүйцэтгэн олон шавь нарыг эрдэмтэн болгон хүмүүжүүлсэн. Профессор Я.Дагвадорж 2012 он хүртэл 18 жил тус тэнхмийг удирдан ажиллахдаа тэнхимийн хамт олныг ямагт дэлхийн шинжлэх ухааны шинэ мэдлэгээр цэнэглэн хөгжүүлж, дагалдуулан сургасны дүнд түүний удирдлагаар тэнхимийн багш Г.Зулхүү, Б.Баярмагнай Р.Оюунгэрэл, Н.Хоролсүрэн, О.Баатархүү нар АУ-ны докторын зэрэг хамгаалж Монгол улсын халдварт өвчин судлалын салбарт тэргүүлэгч эрдэмтэд, багш сурган хүмүүжүүлэгч, эмч мэргэжилтэнүүд болж өссөн (Зураг 36). Тэнхмийн эрхлэгч Профессор Я.Дагвадоржийн халдварт өвчин судлалын салбарт оруулсан хувь нэмрийг үнэлж 2021 онд Монгол улсын Хүний гавъяат эмч цолоор шагнасан.



Зураг 36. Зүүн гар талаас, урд эгнээнд: Г.Зулхүү, тэнхимийн эрхлэгч Я.Дагвадорж, Г.Цэрэндагва, Н.Хоролсүрэн, О.Баатархүү, арын эгнээнд: Р.Оюунгэрэл, С.Оюун, Б.Баярмагнай, Б.Байгал, Г.Ганцэцэг, Д.Оюундэлгэр (2001 он)

2001 оны 4-р сарын 1-ний өдрөөс ЭМЯ-ны харъяа байсан Халдвартын эмнэлэг, Сүрьеэгийн эмнэлэг, Халдварт өвчин судлалын төв (халдвартын диспансер), Сүрьеэгийн үндэсний төв (сүрьеэгийн диспансер), Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн томуугийн, вируст хепатитийн лабораторийг нэгтгэн Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ)-ийг байгуулсаны дараа 2002 оноос эхлэн сүрьеэ болон бэлгийн замын халдварт өвчин (БЗХӨ)-ий сургалт тус тэнхимд харьяалагдах болж АУ-ны магистр БЗДХ/ДОХ-ын их эмч В.Наранцэцэг 1991 оноос Арьс өнгөний тэнхимд багшаар ажиллаж байсан (Зураг 37), сүрьеэгийн их эмч, Анагаах ухааны магистр Д.Оюундэлгэр 1998 оноос дотрын тэнхимд сүрьеэгийн багшаар ажиллаж байсан

(Зураг 38). АУ-ны доктор В. Нямцэнгэл 2007 оноос БЗДХ/ДОХ (Зураг 39), П.Янжиндулам 2011 оноос, сүрьеэ судлал (Зураг 40), АУ-ны магистр Д.Шинэбилэг 2011 оноос БЗДХ/ДОХ-ын (Зураг 41) багшаар тус тэнхимд ажиллах болсон.



ЗУРАГ 37. В.Наранцэцэг, Анагаах ухааны магистр, БЗДХ/ДОХ-ын зөвлөх зэргийн эмч



ЗУРАГ 38. Д.Оюундэлгэр Анагаах ухааны магистр, сүрьеэгийн ахлах зэргийн эмч



Зураг 39. В.Нямцэнгэл Анагаах ухааны доктор, БЗДХ-ын тэргүүлэх зэргийн их эмч



ЗУРАГ 40. П.Янжиндулам, клиникийн Профессор



Зураг 41. Д.Шинэбилэг анагаах ухааны магистр, арьс гоо засал, БЗДХ-ын тэргүүлэх зэргийн эмч

Тэнхим анх байгуулагдсан цагаас халдвартын больниц, эмнэлэг ХӨСҮТ-тэй нягт хамтан ажилладаг байснаас халдварт өвчин судлалын чиглэлээр хэрэгжиж буй эрдэм шинжилгээний томоохон төслүүдэд тухайн үеийн Эрүүл мэндийн сайд асан Академич П.Нямдаваа тэнхмийн багш нарыг татан оролцуулж байнга хамтран ажиллаж байсан нь тэнхмийн эрдэм шинжилгээ судалгааны хөгжилд ихээхэн хувь нэмэр болж байсан. Түүний санаачлагаар тус тэнхмийн багш Дэд профессор Г.Зулхүү, Доктор Н.Хоролсүрэн, Дэд профессор Р.Оюунгэрэл, Профессор О.Баатархүү нар “Монгол улсад томуугийн тандалтын сүлжээг байгуулах”, “Амьсгалын замын хүнд халдвар (SARI – severe acute respiratory infection)” төсөлд оролцож байснаас гадна 2019 онд тархсан КОВИД-19 -ийн цар тахлын эмнэлзүйн судалгааг халдварт өвчин судлалын тэнхимд хариуцуулсан нь үүний нэгэн жишээ билээ. (Зураг 42).



Зураг 42. “COVID -19 цар тахлын лабораторийн оношилгоо” сэдэвт сургалт

Орчин цагийн анагаах ухааны хөгжлийн эхэн үед хүн амын дунд өндөр тархалттай сүрьеэ өвчнийг эмчлэх, илрүүлэх чиглэлээр тусламж үйлчилгээг Оросын эмч мэргэжилтэн гүйцэтгэж байснаа 1947 онд МУИС-ийн Хүн Эмнэлгийн Факультетийн анхны төгсөгчдийн нэг их эмч Р.Нямаа Төв эмнэлгийн харьяа ясны сүрьеэгийн тасагт хувиарлагдан ажилласан үеэс хойш үндэсний мэргэжилтэнүүд төв больницын харьяанд ажиллаж он цагийн хугацаанд өргөжин тэлж байсан сүрьеэгийн тасаг, нэгж, диспансер, амбулаторид сүрьеэгийн тусламж үйлчилгээ, сургалтыг зохион байгуулах болжээ. 1956 оны 6-р сарын 8-ны өдрийн СнЗ-ийн 284/167 тоот тушаалд “...Сүрьеэг анагаах мэргэжлийн боловсон хүчнийг олшруулж тэдний мэргэжлийг байнга дээшлүүлэх ажлыг зохиох...” гэж заасны дагуу МУИС-ийн Хүн Эмнэлгийн Факультетийн оюутнуудад уушгины сүрьеэ өвчний хичээлийг 1956 оноос их эмч А.Дарь, 1958 оноос их эмч н.Чулуун нар зааж, 1960 оноос хүүхдийн сүрьеэ өвчний хичээлийг их эмч н.Дагвасүрэн, яс, үений сүрьеэ өвчний хичээлийг их эмч Заматкинов, н.Ашууррадаа нар зааж байжээ.

1963-1974 онд сүрьеэгийн эмч нарын мэргэжил олгох болон дээшлүүлэх курсыг Сүрьеэ эсэргүүцэх улсын төв диспансераас зохион байгуулж удирдан явуулж байгаад дараа нь АУДС-ийн дотор өвчин судлалын тэнхим АУДС-ийн эмч нарын мэргэжил дээшлүүлэх факультетийн шугамаар хийдэг болсон ба 1972 оноос сүрьеэгийн мэргэжлээр оюутанд заах, эмчийн мэргэжил олгох, дээшлүүлэх, аттестатчлах хөтөлбөрийг боловсруулан АУДС-д мөрдүүлсэн байна.

Монгол улсад сүрьеэ судлалын чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан цөөхөн эрдэмтэдийн нэг нь Гомбогарамын Цогт (1987 онд эрдмийн зэрэг хамгаалсан) бөгөөд тэрээр сүрьеэ судлалын салбарын анхны эрдэмтэн Ч.Гомбогарам (1972 онд эрдмийн зэрэг хамгаалсан)-ын хүү юм. Сүрьеэ судлалын сургалтыг АУ-ны доктор Г.Цогт багш дэлхий дахины сүрьеэтэй тэмцэх бодлоготой нийцүүлэн монгол орны онцлог нөхцөлд тохируулан зохион байгуулж хөгжүүлсэн. Сүрьеэ судлалын хичээлийг Ж.Бадрал багш мөн удирдан явуулдаг байсан.

Халдварт өвчин судлалын салбарын томоохон төлөөлөл болох БЗДХ-ын буюу арьс өнгөний өвчний сургалтын үйл ажиллагаа өнөөгийн арьсны өвчин судлалын тэнхим, тухайн тэнхимийг хөгжүүлсэн Профессор Ч.Долгор багштай салшгүй холбоотой. (Зураг 43-45)



Зураг 43. Баруун гар талаас: Багш Ж.Бадрал (1978 он)



Зураг 44. АУ-ны доктор Г.Цогт багш (1992 он) Оросын лабораторийн эмч нарын хамт



Зураг 45. Профессор Ч. Долгор , Эрүүлийг хамгаалахын сайд Г.Туваан нарын хамт



Зураг 46. АУ-ны доктор, Профессор, МАУА-ийн гишүүн, Академич, халдвартын зөвлөх зэргийн эмч О.Баатархүү

2012-2016 онд Халдварт өвчин судлалын тэнхимийн эрхлэгчээр АУ-ны доктор О.Баатархүү ажиллаж, тэрээр Профессор Я.Дагвадорж багшийнхаа сургаж хүмүүжүүлснээр, тэнхимийн хамт олны дэмжлэг тусламжтайгаар элэг судлалын эрдмийн ажлыг гүйцэтгэж АШУҮИС-ийн профессор, МАУА-ийн гишүүн, Академич, Азийн элэг судлалын холбооны гишүүн, элэг судлалын монгол судалгааг дэлхийд төлөөлөхүйц алдартай эрдэмтэн болтлоо өсөн хөгжжээ. АШУҮИС-ийн гадаад харилцаа хамтын ажиллагаа БНСУ-ын Ионсей их сургуультай өргөжин хөгжиснөөр олон арван багш тус сургуульд мэргэжил дээшлүүлэх, эрдмийн зэрэг ахиулах сургалтанд хамрагдаж

байсны нэг нь О.Баатархүү юм. Тэрээр БНСУ-ын Ионсей их сургуулийн гастроэнтерологийн тэнхимд суралцан тэнхим хоорондын хамтын ажиллагааг 2007-2012 оны хооронд хөгжүүлсэн. Профессор О.Баатархүү 2020 онд АШУҮИС-ийн АУС-ийн захирлаар ажиллаж байсан (Зураг 46)


2016 оноос АУ-ны доктор, дэд профессор Р.Оюунгэрэл (Зураг 47) тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байна. Тус тэнхимд 2017 оноос АУ-ны магистр Э.Энэрэл (Зураг 48), 2018 оноос АУ-ны магистр Г.Долгорсүрэн (Зураг 49), 2020 оноос АУ-ны магистр Б.Мөнх-Ундрах (Зураг 50), 2021 оноос АУ-ны магистр, халдвартын ахлах зэргийн эмч Г.Хоролгарав (Зураг 51) нар багшаар ажиллаж эхэллээ. Тэнхимийн туслах ажилтанаар 2019-2020 онд АУ-ны магистр Ч.Отгонжаргал (Зураг 52), 2021 оноос З.Цэрэннадмид (Зураг 53), үйлчлэгчээр 2021 оноос Ц.Бүжинлхам ажиллаж байгаа бөгөөд 2009-2019 онд тус тэнхимийн үйлчлэгчээр Д.Даваа ажиллаж байсан.




Зураг 47. Р.Оюунгэрэл АУ-ны доктор, дэд профессор, халдвартын зөвлөх зэргийн эмч



Зураг 48. Э.Энэрэл Анагаах ухааны магистр



Зураг 49. Г.Долгорсүрэн Анагаах ухааны магистр



Зураг 50. Б.Мөнх-Ундрах Анагаах ухааны магистр



Зураг 51. Г.Хоролгарав Анагаах ухааны магистр, Халдвартын ахлах зэргийн эмч




ЗУРАГ 52. Ч.Отгонжаргал Анагаах ухааны магистр



ЗУРАГ 53. З.Цэрэннадмид Сувилахуйн ухааны магистр

Тэнхимийн хэмжээнд гадаадын мэргэжилтэн ажиллах үйл ажиллагааг дахин сэргээж 2018 оноос Ким Жюн Руон (БНСУ) тэнхимийн профессороор ажиллах болсон (Зураг 54).




Зураг 54. БНСУ-ын мэргэжилтэн, тэнхмийн профессор, АУ-ны доктор Ким Жюн Руон

Тэнхмийн профессор Я.Дагвадорж, дэд профессор Г.Зулхүү, профессор О.Баатархүү, дэд профессор Р.Оюунгэрэл, АУ-ны доктор В.Нямцэнгэл багш нар Монгол улсын ЭМЯ-ны мэргэжлийн салбар зөвлөл, Монголын халдвартын эмч нарын нийгэмлэг, БЗДХ/ДОХ-ын нийгэмлэг, Монголын элэгний эмч нарын нийгэмлэг зэрэг мэргэжлийн ТББ-ыг удирдан чиглүүлж улсын хэмжээнд мэргэжилтэний манлайллаа баталсаар байна.

Халдварт өвчин судлалын тэнхим сургалт, мэргэжлийн үйл ажиллагааг тэргүүлэн гүйцэтгэхийн зэрэгцээ халдварт өвчний судалгаа шинжилгээг хөгжүүлсэний нотолгоо нь вируст хепатит, бруцеллез, менингококт халдвар, суулгалт халдвар, улаанбурхан, сүрьеэ, КОВИД-19 зэрэг чиглэлээр эрдэм шинжилгээний 20 гаран төсөлт судалгааг хэрэгжүүлж, 40 гаран АУ-ны доктор, АУ-ны магистрийг бэлтгэн гаргажээ. Тэнхимийн эрдэм судлалын ажлын амжилтын 90 гаруй хувь нь Профессор Я.Дагвадоржтой салшгүй холбоотой юм.

Сүүлийн жилүүдэд тэнхимийн эрхлэгч дэд профессор Р.Оюунгэрэл, АУ-ны доктор ахлах багш В.Нямцэнгэл нар БНСУ-ын “ВУНО” байгууллагатай хамтран “КОЙКА” Олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр 2016 оноос хойш “Трихомониаз өвчний компьютерт суурилсан оношилгоог хөгжүүлэх нь 2016-2018” төслийн хүрээнд бэлгийн замаар дамжих халдварт өвчин заг хүйтэн, трихомониазис, шээс бэлгийн замын кандидоз өвчнийг үүсгэгч *T.vaginalis, N.gonorrhoeae, C.albicans* гэсэн 3 бичил биетийг нэг наацад илрүүлэх хиймэл оюун ухааны TRI-VU оношилгооны программыг нэвтрүүлсэн нь Монгол улсын эрүүл мэндийн түүний дотор халдварт өвчин судлалын салбарт хиймэл оюун ухаан технологийг нэвтрүүлсэн анхдагч байгууллага болж байгаа юм. Тэнхимийн хамт олон цаашид сүрьеэгийн оношилгоонд хиймэл оюун ухааны технологийг нэвтрүүлэн сүрьеэгийн илрүүлгийг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлэн зөөврийн рентген багаж бүхий тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан нь тэнхмийн түүхэн хөгжлийн хугацаанд олсон томоохон амжилт юм.

Өнөөгийн түвшинд халдвартын тэнхим нь Профессор Я.Дагвадоржийн 30 жилийн тэртээгээс байгуулсан цомхон лабораторийг өргөтгөн БЗДХ, сүрьеэг илрүүлэх орчин үеийн хамгийн дэвшилтэт технологи хиймэл оюунд суурилсан оношилгооны програм бүхий багц багаж төхөөрөмжтэй тэнхим болж хөгжин Монгол улсын хэмжээнд халдварт өвчний тархалтыг хязгаарлах, нас баралтыг бууруулах, хүн амыг халдварт өвчнөөс сэргийлэх үйлсэд тэргүүлэгч гэдгээ дахин баталж байна (Зураг 55,56).



Зураг 55. Оношилгооны хиймэл оюун ухааны програм хангамж суурилагдсан компьютерт үүсгэгч оношлогдсон жишээ



Зураг 56. Цээжний рентгенд хиймэл оюун ухааны технологи ашиглан оношилсон байдал

Халдварт өвчин судлалын сургалтыг АШУҮИС-ийн Сувиалхуйн сургуульд Монгол улсын Хүний Гавъяат эмч В.Гаамаа, Монгол улсын Гавъяат багш Г.Цэрэндагва (1956-1968 онд), Монгол улсын Ардын эмч Ч.Долгор (1958-1960 онд), С.Лхүндэв (1961-1964 онд), Ч.Эрдэнэсан (1961-1988 онд), А.Цэнджав (1967-1996 онд), Г.Гандан (1967-1992 онд), Г. Дорж (1967-1989 онд), Ц.Дамдин (1968-1989), Ж.Даваажав (1974-1978 онд), Б.Дэлгэр (1975-1980 онд), Х.Даваасүрэн (1986-1992 онд), С.Жанчив (1987-1990 онд), Б.Хишигдэлгэр (1987-1992 онд), Д.Чимэд (1989-2009 онд), Б.Энхзаяа (2011-2013 онд), Д.Гантулга (2011-2013 онд), Э.Бат-Өлзий (2011 оноос өнөө хүртэл) нар удирдан зохион байгуулсаар иржээ.

Халдварт өвчин судлалын тэнхмийн багш Анагаах ухааны доктор дэд профессор Г.Зулхүүгийн санаачлагаар эхлэлтэй Монголын Халдвартын эмч нарын нийгэмлэг нь 2011 оны 11-р сарын 02-ны өдөр Монгол улсад албан ёсоор бие даасан төрийн бус байгууллага болон батламжлагдсан. Нийгэмлэг нь албан ёсны 200 орчим гишүүнтэй, гишүүдэд үйлчлэх ашгийн бус байгууллага бөгөөд 2019 онд анхдугаар чуулга уулзалтаа зохион байгуулсанаар үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлэх нөхцөл боломж бүрдсэн (Зураг 57). Дэлхий дахиныг хамарсан халдварт өвчний цартахал, Монгол улсад тархсан тахалт дэгдэлт, дэгдэлт, халдварт өвчний алаг цоог тохиолдол бүрт халдвартын эмч нар тэргүүн шугаманд ажиллаж байгаа баатрууд билээ.



Зураг 57. Монголын халдвартын эмч нарын анхдугаар чуулга уулзалт (2019 он)

Халдварт өвчин судлалын эмч нарын дундаас (халдварт, сүрьеэ, БЗДХ/ДОХ) 10 гаруй эмч Монгол улсын гавъяат цолтон, 20 гаруй Анагаах ухааны доктор, 19 орчим Зөвлөх зэргийн эмч, 60 гаруй тэргүүлэх зэргийн эмч төрөн гарчээ.

АШУҮИС-ийн ууган дөрвөн тэнхимийн нэг Халдварт өвчин судлалын тэнхим нь Монгол улсын эрүүл мэнд түүний дотор халдварт өвчин судлалын салбарт сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааг монгол орны хэрэгцээ

төдийгүй дэлхий дахины жишигт нийцүүлэн ахмад үеийн түүхэн уламжлалаар ирээдүй үеийг бэлтгэн хөгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна (Зураг 58)



Зураг 58. Зүүн гар талаас, урд эгнээнд: Г.Хоролгарав, тэнхмийн эрхлэгч Р.Оюунгэрэл, О.Баатархүү, З.Цэрэннадмид, арын эгнээнд: Э.Энэрэл, Г.Долгорсүрэн, Д.Шинэбилэг, В.Нямцэнгэл, Б.Мөнх-Ундрах.

Талархал: Түүхэн материалыг бичиж тэмдэглэсэн Доцент Г. Дуламсүрэн, Дэд профессор Л.Дамдинсүрэн, Гавъяат багш Г.Цэрэндагва, Профессор Я.Дагвадорж, Дэд профессор Г.Зулхүү, Профессор О.Баатархүү болон тэнхмийн үе үеийн хамт олон, архивийн материалтай танилцсан тэнхмийн багш В.Нямцэнгэл, Э.Энэрэл, Г.Долгорсүрэн, Б.Мөнх-Ундрах, Монгол улсын Архивийн ерөнхий газрын мэргэжилтэн Түүхийн ухааны магистр Б.Ренчинноров нарт талархал илэрхийлье!

АШУҮИС-ийн АУС-ийн халдварт өвчин судлалын тэнхмийн эрхлэгч АУ-ны доктор дэд профессор, Монголын халдвартын эмч нарын нийгэмлэгийн тэргүүн Р. Оюунгэрэл

Ном зүй:

1. Л. Энхбаатар (2006) //Бэлгийн замын халдварт өвчинтэй тэмцсэн түүх
2. Т. Ядамсүрэн (2007) //Арьс өнгөний өвчинтэй тэмцэх албаны түүх, Түүхэн замнал
3. Ц. Чулуунбаатар, Д. Батсүх, Т. Долгор, Б. Нямсүрэн, М. Саран, Д. Төмөрбаатар, Ш. Хишгээ (2000) //Бүгд Найрамдах Монгол Ард Улсад гоц аюулт халдварт өвчинтэй тэмцэж ирсэн түүх (1885-1995), I боть
4. Л. Энхбаатар, Н. Чулуун, Н. Наранбат (2004) //Сүрьеэтэй тэмцсэн нь
5. Монгол улсын шинжлэх ухаан 98-р боть, 2011 он
6. Ц. Чулуунбаатар (2001) //Монгол дахь гоц аюулт халдварт өвчний хяналтын тухай түүхэн товчоон”
7. Сувилахуйн нэгэн зуун 1921-2021, 2021 он Д. Сүх (1987) // Халдварт өвчнийг анагаах улсын клиникийн төв эмнэлэг-40 жил
8. МУИС-ийн 1946-1947 оны хичээлийн төлөвлөгөө (1947) // Төв архивийн материал
9. Монголын анагаахын мэргэд (2012) Их багштан Цорос Ганжаан Жамба, XVII боть
10. Д. Сүх (1987) Халдварт өвчнийг ангаах клиникийн эмнэлэг -40 жил
11. Анагаахын мэргэд гарахын орон (2002) //Монгол улсын анагаах ухааны сургуулийн нэгэн жарны түүх
12. Монгол улсын Үндэсний төв архивийн бусад материал

ЭЛГЭЭ ХАМГААЛЖ, ЦӨСӨӨ ШИНГЭЛЬЕ!

digest active
Дайжест актив



Толбот силибум (Силимарин)



125мг

Элэг хамгаалах, үрэвслийн эсрэг, антиоксидант, хоргүйжүүлэх

- Липидийн хэт исэлдэлтийг өдөөдөг чөлөөт радикалуудыг устгагчийн үүрэг гүйцэтгэдэг тул гэмтээгүй эсүүд болон эргэн сэргэх боломжтой элэгний эсийг хамгаалж, фиброз, элэгний хатуурлаас сэргийлдэг.
- Элэгний эсийн нөхөн төлжилтийг идэвхжүүлэх, антифибротик, холеретик үйлдэлтэй.
- Цусан дахь сахар болон инсулины хамаарлыг зохицуулдаг.
- Глютатионы нийлэгжилтийг идэвхжүүлдэг.

Артишок



200мг

Элэгний эсийн үхжилээс хамгаалах, лидидийн солилцоог идэвхжүүлэх, цөс ялгаруулах

- Устөрөгчийн хэт ислээр үүсгэгдсэн элэгний эсийн липидийн периоксидазийг дарангуйлснаар элэгний эс гэмтэл болон үхжилээс хамгаалдаг.
- Өөх тосны солилцоог дэмжиж элэгний өөхлөлтийг бууруулдаг.
- Найрлага дахь цинарин нь холеретик, холерекинетик үйлдэлтэй.

Цайр



240мг

Элэгний эсийн бодисын солилцоог идэвхжүүлэх, антиоксидант, үрэвслийн эсрэг

- Мочевин болон глутамины синтезын цагирагийн фермент болох орнитин транскарбамилаза ба глутамат дегидрогеназыг идэвхжүүлэхэд цайр оролцдог.
- Супероксид дисмутаза (SOD)-ийг идэвхжүүлж, идэвхгүй хүчилтөрөгчийн (ROS) түвшинг бууруулснаар хорт хавдар үүсгэхэд хүргэдэг эпигенетик модуляци багасна. Мөн фиброз үүсэх явцыг багасгаснаар hepatocellular carcinoma (HCC) үүсэх эрсдлийг бууруулдаг.
- Эсийн гаднах ATP клиренс болон аденозины үүсэлтийг хэвийн болгоход оролцдог мөн ДНХ полимераз, РНХ полимераз, шүлтлэг фосфатаза ферментүүдийн нийлэгжилтэд цайр оролцдог.

Кальци



3мг

Өөх тос солилцооны ферментүүдийг идэвхжүүлэх

- Кальци нь элэгний липогенезийн идэвхжил, улмаар липидийн хуримтлалаар өдөөгдсөн исэлдэлтийн үрэвслийн хариу урвалыг бууруулдаг. Элэгний өөхлөлт нь антиоксидант ферментүүдийн идэвхжилийг бууруулж, липидийн хэт исэлдэлтийг нэмэгдүүлснээр, интерлейкин-6 (IL-) зэрэг үрэвслийн цитокинин, хавдрын үхжилийн хүчин зүйл-α (TNF-α) нэмэгдүүлдэг тул энгийн элэгний өөхжилтөөс элэгний хатуурал хүргэх ноцтой үр дагавартай.

ДАЙЖЕСТ АКТИВ ХЭН ХЭРЭГЛЭХ ВЭ?

- Элэгний эмгэг (вирусын болон хордлогын шалтгаант хурц болон архаг гепатит, эм, хорт бодисын шалтгаант элэгний эмгэг, элэг өөхлөлт, элэгний хатуурал, элэгний хавдар)
- Цөс өтгөрөл болон зогсонгишил
- Элгэнд нөлөөлөл ихтэй эм, антибиотик ууж буй үед
- Өөх тос ихтэй хоол хүнс хэрэглэдэг болон зохисгүй хооллолт, архи согтууруулах ундаа хэрэглэдэг
- Стресс, оюуны ачаалал ихтэй болон ахимаг насны хүмүүс





Хэрэглэх арга: Хоногт 1-2 бүрээсийг хооллох үедээ хангалттай хэмжээний шингэнээр даруулж ууна.

Утас: 99065696, 99076493

Бүх эмийн сангуудаар

Denk Pharma QUALITY FOR YOUR HEALTH - MADE IN GERMANY

Denk

electrolyte

Электролит

ЦАЙР АГУУЛСАН



ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу эрдэс бодис ба ЦАЙР агуулсан шингэн нөхөх гипотоник уусмал (251 mOsm/L)

Найрлага:	Нэг уутанд агуулагдах хэмжээ	1000мл буюу 5 уутанд агуулагдах хэмжээ
Цайр	1,5мг	7,5мг
Кали	157мг	785 мг
Хлорид	458мг	2290 мг
Натри	341 мг	1705 мг
Глюкоз	2,7 гр	13,5 гр

ЦАЙР

Цайр нь дархлалын тогтолцооны үйл ажиллагаанд болон нарийн гэдсэнд ус, эрдэс давсны зөөвөрлөлтөд нэн чухал үүрэгтэй.

Zn

The NEW ENGLAND JOURNAL *of* MEDICINE[1]

Хүүхдийн суулгалтын үед бага тунт цайрын бэлдмэл хэрэглэх нь

Олон төвт, давхар нууцлалтай, санамсаргүй түүвэрлэлтийн аргаар хийсэн эмнэлзүйн туршилт судалгаа

Цочмог суулгалттай 6-59 сартай 4500 хүүхдэд хийсэн судалгаа	5 мг (N=1504)	10 мг (N=1498)	Стандарт 20 мг (N=1498)
Суулгалт 5 хоногоос удаан үргэлжилсэн хүүхдийн %	7,2% Эрсдэлийн зөрүү нь 0,7%, дээд хязгаар 98,75% CI, 2,8	7.7% Эрсдэлийн зөрүү нь 1.2%, дээд хязгаар 98,75% CI, 3.3	6.5%
Цайрын бэлдмэл уснаас 30 минут дотор бөөлжсөн хүүхдийн %	13.7% RR 0,71; 97,5% CI, 0,67-0,96	15.6% RR 0,81; 97,5% CI, 0,59-0,86	19.3%

Стандарт 20мг тунгаас бага тунгаар өгөхөд үйлдэл сайн байсан төдийгүй бөөлжилтийг бууруулсан.

CI-Confidence interval (итгэх интервал), RR-Relative risk (харьцангуй эрсдэл)

Хэрэглэх арга:

- 1 уут бэлдмэлийг 200 мл усанд найруулж ууна.
- Хүүхэд, насанд хүрэгсэд болон чихрийн шижинтэй хүмүүст хэрэглэж болно.

Хэрэглэх заалт:

- ✓ Бөөлжилт, суулгалт, хордлого
- ✓ Халууралт
- ✓ Эрчимтэй дасгал хөдөлгөөн, биеийн хүчний хэт ачаалал, халуун, хуурай нөхцөлд ажиллаж байгаа үед





Цайр агуулсан шингэн сэлбэх давсны уусмал нь бусад энгийн уусмалтай харьцуулахад суулгалтын үргэлжлэх хугацааг 25-30%-иар богиносгодог.



Эрчимтэй дасгал хөдөлгөөн хийхэд цагт 1-3 л хөлс алддаг. Хөлс нь давслаг амттай байдаг нь бидний биопроцесс, булчинг хэвийн ажиллуулахад шаардлагатай устай хамт эрдэс бодисоо алддагтай холбоотой. Биеийн жинтэй харьцуулахад 1-2% ус алдах нь шингэн алдалтын анхны шинж тэмдгүүдэд хүргэдэг бөгөөд энэ нь бие махбодийн болон оюун санаа сэтгэл зүйн чадварыг бууруулдаг. Усны 5% алдагдал нь гүйцэтгэлийг 1/3 хүртэл хязгаарлаж болдог. Иймээс дасгал хийх явцад цагт 0.4-0.8 литр ШСДУ уух нь дасгалын гүйцэтгэлийн түвшинг хадгалж нэмэгдүүлдэг.



Мэс заслын өмнө болон дараа амаар шингэн уух боломжтой өвчтөнд ШСДУ хэрэглэснээр өлсөх, ам хуурайших мэдрэмж, сэтгэл түгшүүрийг багасган, шингэн ба эрдэс нөхөх аюулгүй үр дүнтэй эмчилгээний арга юм.[2]



Хавдрын хими эмчилгээнд ШСДУ хэрэглэх нь усгүйжилтийн шинж, хордлогыг багасган амьдралын чанарыг сайжруулахад нөлөөлнө.[3]

[1]U.Dhinga et.al. 10.1056/NEJMoa1915905 Copyright2020. Massachusetts Medical Society

[2]https://www.researchgate.net/publication/24429559

[3]Sato et al. Journal of Pharmaceutical Health Care and Sciences (2016) 2:6
DOI 10.1186/s40780-016-0041-z

Утас: 99045634, 89003868

Denk Pharma QUALITY FOR YOUR HEALTH - MADE IN GERMANY